

# “ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

№ ХЭХ 01/2020

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус  
хурлын дарга сонгох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг болон “Хар хорум пропертийс” ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын даргаар Базар овогтой Батхүүг сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТХҮҮ/

# “ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

№ ХЭХ 02/2020

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

“Хар хорум пропертийс” ХК-д  
“Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх  
замаар өөрчлөн байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1, 18.5 дахь хэсэг, 20 дугаар зүйл, 24 дүгээр зүйл, 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.1, 53.2, 53.5 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.3, 62.1.11, 62.1.12, 62.1.15, 62.2.5, 62.2.10, 62.2.12, 87 дугаар зүйлийн 87.1, 87.2 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, “Хар хорум пропертийс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг болон Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг “Хар хорум пропертийс” ХК-д шилжүүлсүгэй.
3. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан “Хар хорум пропертийс” ХК-ийн оноосон нэрийг “Эрдэнэс сольюшинс” ХК оноосон нэрээр өөрчлөх болон оршин байгаа газрыг Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 401 тоот хаягт байрлан үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсүгэй.
4. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэж байгаатай холбогдуулан “Хар хорум пропертийс” ХК-ийн одоогийн эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлд дараах үйл ажиллагааг хугацаагүйгээр эрхлэхээр нэмсүгэй. Үүнд:
  - 4.1.1. гадаад худалдаа;
  - 4.1.2. программ хангамжийн үйл ажиллагаа;
  - 4.1.3. программ хангамж, компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа;
  - 4.1.4. вэб сайт хийх;
  - 4.1.5. вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх;
  - 4.1.6. мэдээллийн технологи;
  - 4.1.7. худалдааны зуучлал.

5. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл”-ийг энэхүү шийдвэрийн Нэгдүгээр хавсралтаар, ““Хар хорум пропертийс ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх гэрээ”-г энэхүү шийдвэрийн Хоёрдугаар хавсралтаар дэмжин баталж, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсугай.
6. Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн жилд буюу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн “Пи Кэй Эф Монголиа Аудит” (Координат аудит) ХХК-ийн гаргасан аудитын дүгнэлтийг энэхүү шийдвэрийн Гуравдугаар хавсралтаар баталсугай.
7. Компанийн сүүлийн нэг жилийн хугацааны дотор хийсэн “Мөнх-Оргил трэйд” ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайланг энэхүү шийдвэрийн Дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
8. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан болон хөрөнгийн үнэлгээний тайланг хүлээн зөвшөөрсүгэй.
9. “Хар хорум пропертийс” ХК болон “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайланд үндэслэн “Хар хорум пропертийс” ХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 (нэг) ширхэг энгийн хувьцаанд “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 (нэг зуун) ширхэг энгийн хувьцаатай хувь тэнцүүлэн хөрвүүлж нэгтгэсүгэй.
10. Энэхүү шийдвэрийн 8 дахь хэсэгт шийдвэрлэсний дагуу “Хар хорум пропертийс” ХК-ийн зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 (нэг) ширхэг нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 (арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр) ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд эргэлтэд нэмж гаргасугай.
11. “Хар хорум пропертийс ХК”-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэсний үр дүнд бий болсон хувьцааны 0.3 (тэг аравны гурван) үлдэгдлийг Компани халаасны хувьцаа болгон худалдан авахаар шийдвэрлэсүгэй.
12. Энэхүү шийдвэрийн 8, 9, 10 дахь хэсэгт шийдвэрлэсний дагуу “Хар хорум пропертийс ХК”-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэсний дараах Компанийн хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийг энэхүү шийдвэрийн Тавдугаар хавсралтаар баталсугай.
13. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргасан хувьцаанаас “Хар хорум пропертийс” ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
14. “Хар хорум пропертийс ХК”-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүссэн тул холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд

мэдэгдэн, худалдан үнэ тогтоох, авах үйл ажиллагааг зохион байгуулахыг шинээр сонгосон Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

15. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулсантай холбогдуулан компанийн Дүрмийг энэхүү шийдвэрийн Зургаадугаар хавсралтаар баталсугай.
16. ““Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх гэрээ”-нд “Хар хорум пропертийс” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг энэхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах өдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй хувьцаа эзэмшигч иргэн Б.Батхүүд олгосугай.
17. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэгдсэн асуудлыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид холбогдох журмын дагуу мэдэгдэж, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах зөвшөөрөл авах болон бусад дагалдан гарсан шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг энэхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах өдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй хувьцаа эзэмшигч иргэн Б.Батхүүд олгосугай.
18. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах, “Хар хорум пропертийс” ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргаж байгаа хувьцааг бүртгэж, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс гаргасны дараа Компанийн Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Компанийн оноосон нэр, хаягийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт холбогдох журмын дагуу бүртгүүлэх болон энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг энэхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах өдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй хувьцаа эзэмшигч иргэн Б.Батхүүд олгосугай.
19. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй хувьцаа эзэмшигч иргэн Б.Батхүүд энэхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даалгасан ажил үүргээ хэрэгжүүлэх, олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ Компанийн албан ёсны тэмдэг /тамга/-ийг Компанийн хяналт дор ашиглах эрхийг олгосугай.



/Б.БАТХҮҮ/

# “ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр

№ ХЭХ 03/2020

Улаанбаатар хот

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
 гишүүдийг шинээр сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.15 дахь заалт болон “Хар хорум пропертийс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын санал хураалтын дүнгийн шийдвэрийг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

1. “Хар хорум пропертийс” ХК-ийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан одоо байгаа Төлөөлөн удирдах зөвлөл, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.
2. “Хар хорум пропертийс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр 3 жилийн хугацаатайгаар шинээр сонгосугай.

Ердийн гишүүнээр:

Ц.Хүдэрмөнх  
Т.Золбоо  
Б.Батхүү  
Ц.Хишигбаатар  
Э.Цэндсүрэн  
Г.Аззаяа

Хараат бус гишүүнээр:

Б.Энхзориг  
С.Энхжаргал  
П.Нарантунгалаг

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгосонтой холбогдуулан төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг хуульд заасан журмын дагуу сонгож баталгаажуулах, “Хар хорум пропертийс” ХК-ийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан тус Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлаас гаргасан тухайлан хэрэгжүүлэхийг зааснаас бусад асуудлаар шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТХҮҮ/